

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

*Н*ээлттэй Нийгэм Форум, Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээний байгууллагууд хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг судалж, хэлэлцлээ.

2016 оны 2 дугаар сард баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар өмнө нь баримталж ирсэн эрүүл мэндийн хандлагаас татгалзаж, тэдний эрх тэгш оролцоог хангахад чиглэсэн, урт хугацаандаа үр нөлөөтэй хууль болсныг онцлон тэмдэглэж байна. Уг хууль нь хөгжлийн бэрхшээлийг шинэ, хүний эрхэд суурилсан хандлагаар тодорхойлж, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлахыг эрс шийдэмгий хориглохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, бусад хүмүүстэй хамт боловсролд тэгш хамрагдах зэрэг эрхийг баталгаажуулжээ. Эрхийг тунхаглаад зогсолгүй хүртээмжтэй орчин, бүтээгдэхүүн үйлчилгээний түгээмэл загвар, хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн зэрэг эрхийг хангах механизмыг тодорхой заасан нь уг хуулийн давуу тал юм.

Хуулийн “Сурч боловсрох эрх” нэртэй 4 дүгээр бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүх шатны боловсролд тэгш хамруулах зорилт дэвшүүлж, энэ чиглэлд төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлжээ. Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн бодлогын зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтод нийцэж байгааг сайшаан дэмжиж, хуулийн дэвшилттэй, шинэлэг талыг цохон тэмдэглэхийн зэрэгцээ шүүмжлэлтэй зарим асуудлыг энэхүү Хуулийн шүүмжээр хүргэж байна.

Санал, шүүмж

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуульд хөгжлийн бэрхшээлийг хүний эрхэд суурилсан хандлагаар шинээр тодорхойлсон (4.1.1) нь нэн сайшаалтай. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзалгүй бий болгосон орчин нь тэдний оролцоог хязгаарлаж, улмаар хөгжлийн бэрхшээлийн шалтгаан болж байгааг хүлээн зөвшөөрсөн байна.

2005-2016 онд хэрэгжиж байсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлийг хүний эрүүл мэндийн доройтол гэж тодорхойлсон нь тэднийг хөдөлмөрлөх, сурах чадвараа бүрэн юмуу тодорхой хувиар

алдсан хүн гэсэн ойлголтыг бий болгож, улмаар тэдний сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд саад болж ирсэн. Хөгжлийн бэрхшээлийн эмнэлгийн загвар гэж нэрлэгддэг энэ ойлголтыг халж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ эдлэх боломж бололцоог олгосон эрх зүйн шинэ тодорхойлолт боловсруулж, батлахыг хүний эрхийн олон улсын байгууллагууд удаа дараа Монгол Улсад зөвлөж¹ байжээ. 2016 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуульд “хөгжлийн бэрхшээл бол хүний согог, орчны саадтай нийлснээр бий болж байгаа оролцооны хязгаарлалт” гэж тодорхойлсон нь дээрх зөвлөмжүүдтэй нийцжээ. Улмаар энэхүү шинэ тодорхойлолт нь дэд бүтэц, нийтийн үйлчилгээ, мэдээллийн суваг зэрэг орчин хүрээлэлд агуулагдаж байгаа саад тотгоруудыг арилгаж, хүртээмжийг сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал хөшүүрэг болох юм.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэй (14.1) бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролд бүрэн хамруулах (14.3.2) тухай уг хуульд заасан нь тэгш хамруулан сургах бодлогод нийцжээ. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн ангид бусад хүүхэдтэй хамт суралцаж, үндэсний стандартыг хангасан боловсрол эзэмших боломж баталгаажиж байна. Үүний зэрэгцээ Бага, дунд боловсролын хуульд туссан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд сургах заалт хүчинтэй хэвээр байгаа ба хүүхдээ тусгай, эсвэл ердийн сургуульд сургах сонголт эцэг, эхчүүдэд нээлттэй хэвээр байна.
3. Тэгш хамруулан сургах бодлогыг тунхаглаад орхилгүй, хэрэгжилтийг хангах механизмыг уг хуульд зааж өгчээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасан (14.1.3, 15.1) нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилтыг дэмжих чухал бодлого юм. Өнөөдөр “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, сургуулийн бага ангид суралцаж байгаад... дунд, ахлах ангид 14 хувь болж буурдаг”² байдлыг засаж сайжруулахад хуулийн уг заалт чухал үүрэг гүйцэтгэх юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг үнэлэх, үнэлгээнд түшиглэн ганцаарчилсан дэмжлэгийг тодорхойлох арга зүйг боловсруулж, нэвтрүүлэх шаардлагатай юм. Хэрэгцээг стандартчилж болохгүй ч хэрэгцээг тодорхойлох үйл явц, процессыг нэгдсэн байдлаар тогтоох ёстой.
4. Хуульд багшийн мэргэжлийн бэлтгэлийг хангуулах (16 дугаар зүйл), хүртээмжтэй орчин бий болгох, тусгай хэрэгсэл худалдаж авах сургуулийн үүргийг тодорхой заагаад (15.1.1-15.1.2, 15.1.4-15.1.7), үүнд зориулах зардлыг БСШУСЯ болон орон нутгийн тухайн жилийн төсөвт суулгахаар заасан (15.7, 15.9, 15.10) нь төлөвлөлт, санхүүжилтийг тодорхой эзэнтэй болгож, хөрөнгө мөнгө дутах эрсдэлээс сургуулийг хамгаалж өгсөн байна. Мөн уг зардлыг тухайн жилийн төсөвт тусгахын тулд боловсролын болон орон нутгийн удирдлага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо, хэрэгцээг 3 дугаар сар гэхэд (төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-аар батлахаас өмнө) гаргасан байх шаардлагатай. Энэ нь хэрэгжүүлэхэд төвөгтэй, ажлын ачааллыг

1 Жишээлбэл, 2015 онд ХАХНХЯ-ны дэд сайд Б.Мөнхбаатар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн анхны тайланг НҮБ-д танилцуулсны дараа хэлэлцүүлгийн үеэр энэ асуудал хөндөгдөж байжээ. <http://drpi.research.yorku.ca/crpd-considers-initial-report-of-mongolia/>

2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг хангах үндэсний хөтөлбөр

нэмэгдүүлэх мэт харагдаж болох ч сургууль, орон нутгийн засаг захиргааны уялдаа холбоо, төлөвлөлтийг сайжруулах сайн талтай. Нөгөө талаас, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог орон нутаг тус бүрээр гаргавал нүсэр биш тул энэ ажил нь сургууль, орон нутагт эрс ачаалал үүсгэхгүй. Тухайлбал, Архангай аймагт хөгжлийн бэрхшээлтэй нийт 220 гаруй хүүхэд, аймгийн төвөөс бусад сумдад тус бүр 10 хүрэхгүй хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн насны хүүхэд байна.

5. Тэгш хамруулан сургах боловсролын үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд багш, мэргэжилтний бэлтгэлд онцгой анхаарсан нь нэн сайшаалтай. Бүх шатны боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, арга барил эзэмшсэн багш, нийгмийн ажилтантай байхыг (16.2) шаардан, энэ шаардлагыг хангах зорилгоор сургуульд ажиллах багш, нарийн мэргэжлийн засалч, сэтгэл зүйч, арга зүйчдийг гадаад дотоодын их дээд сургуульд төрийн зардлаар сургахаар (16.4) төлөвлөжээ.
6. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ хэрэгжүүлэхэд сургууль, хорооны нийгмийн ажилтан мэдээллээр хангаж хамтран ажиллах үүрэгтэй (14.4) болжээ. Энэ нь хүүхдээ сургуульд элсүүлэх, үргэлжлүүлэн сургах асуудлаар оролцох, нөлөөлөх эрх мэдэл багатай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд тун чухал дэмжлэг юм.
7. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд боловсролын үйлчилгээ хүргэх, ингэхдээ үйлчилгээний төлөвлөгөөг харьяа сургуулийн мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотой боловсруулахаар (15.4) заасан нь тун сайшаалтай. Өдрийн ангид хамрагдах боломжгүй хэвтрийн, байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд сайн дурынхан, эсвэл төсөл хөтөлбөрийн хүрээнд түр сургалт зэргээр боловсролын үйлчилгээг үзүүлж ирсэн байдлыг халж, харьяа сургууль хариуцах болжээ. Гагцхүү мэргэжил арга зүйн зөвлөл гэх бүтэц ерөнхий боловсролын сургууль дээр байхгүй тул шинээр байгуулах эсэхийг тодорхой зааж өгөх шаардлагатай.
8. Хуулийн зарим заалт боловсролд тэгш хамруулан сургах зарчмыг ноцтой зөрчиж байгааг даруй залруулах шаардлагатай байна. Тэгш хамруулан сургах боловсрол бол хөгжлийн бэрхшээл, бусад шалтгаанаас үүдсэн онцлог хэрэгцээтэй сурагчдыг ердийн сургуульд шаардлагатай дэмжлэгээр ханган амжилттай сургаж, үндэсний стандартад нийцсэн боловсрол эзэмшүүлэх бодлого билээ. Гэтэл уг хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлого, арга хэмжээний хажуугаар уламжлалт хандлагаар тусгай стандарт, хөтөлбөрөөр, тусгай ангид сургах арга хэмжээ авахаар заасан нь зөрчил үүсгэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдаас ялгаатай стандарт, хөтөлбөрөөр сургах нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил төдийгүй хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан явдал билээ. Иймд хуулийн 14.1.4, 15.1.3, 15.3 дугаар заалтыг бүхэлд нь, 14.3.2 дугаар заалтаас “тухайн хүүхэд, залуучуудын онцлог хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах” гэсэн хэсгийг, 15.11 дүгээр заалтаас “сургалтын хөтөлбөр” гэснийг хасах саналтай байна.
9. Хуульд дохионы хэл, Брайль үсэг ашиглах, орон зай, чиг баримжааны чадвар олгох тухай (15.1.5) тодорхой заасан нь зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад чухал дэмжлэг болох тул сайшаан дэмжиж байна. Үүний зэрэгцээ, сургалтын явцад

үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох боломжид нөлөөлдөг аутизм, оюуны бэрхшээл, тархины саажилт, анхаарал төвлөрлийн эмгэг зэрэг бэрхшээлтэй холбоотой хэрэгцээ, дэмжлэг, нэмэлт үйлчилгээг тодорхойлж, хуульд тусгах шаардлагатай юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцид “Брайль болон түүнтэй төстэй үсэг, нэмэлт болон сонголттой арга, төрөл хэлбэр, харилцаанд ашиглах бусад хэв маяг, түүнчлэн орон зайг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх”, мөн “... боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцааны бусад хэв маягаар олгох явдлыг хангах” гэж заасан байдагт уг заалтыг нийцүүлэн өргөжүүлэх хэрэгтэй.³

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил үндсэн эрх, эрх чөлөөгөө тэгш эдлэхэд онцлог хэрэгцээнд нь нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч, үүнд “тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг” хамруулна (4.1.3) гэж тайлбарлажээ. Гэвч “Сурч боловсрох эрх” бүлэгт тохирох хэрэглэгдэхүүн гэсэн нэр томъёог огт хэрэглээгүй, сурагчийн онцлог хэрэгцээнд тохирох ном, сурах бичиг, гарын авлага материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах (15.1.2, 15.11) буюу зөвхөн материаллаг эд зүйлсийг заасан нь учир дутагдалтай юм. Материаллаг хангамжийн зэрэгцээ 4.1.3 дугаар зүйлд тодорхой дурдсан програм хангамж, орчин нөхцөл, үйлчилгээ зэрэг тохирох хэрэглэгдэхүүний бусад хэлбэр орхигдсон байгааг нэмж хуульчлах шаардлагатай.

Тодорхой болгох шаардлагатай асуудлууд

11. 15.1.4-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил” гэсэн нь сурах чадавхыг хөгжлийн бэрхшээлд шууд хамааруулсан, хөгжлийн бэрхшээлээс болж тусгайлсан арга зүй, арга барилаар сурна гэж ойлгогдох эрсдэлтэй тул энэ хэсгийг оновчтой найруулах хэрэгтэй.
12. Хуулийн 16.3 дугаар зүйлд багшийн арга зүйн сургалтыг төрийн бус байгууллагаар хийлгэж болно гэж заажээ. Тэгш хамруулах боловсролын бэлтгэлийг эрчимжүүлэх үүднээс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн боломж олгож байгааг сайшаан хүлээн авч байгаа ч сургалт явуулах төрийн бус байгууллагыг сонгохдоо чадавх, мэдлэг, чадварын шаардлагыг баримталж, ил тод үйл явцаар сонгоход анхаарна уу.

³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн эхийг Монгол хэл рүү шинээр орчуулж, орчуулгын чанарыг сайжруулах тулгамдсан хэрэгцээ байгааг анхаарна уу.

Дугаарыг эрхэлсэн: А.ГЭРЭЛМАА
ННФ-ын Боловсрол, нийгмийн
бодлогын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамьян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn



“ТҮГЭМЭГТ ХӨГЖИЛ”
БИЕ ДААН АМЬДРАХ ТӨВ



Хөгжлийн Бэрхшээлтэй
Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо

